



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2022 оны 5 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 78

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай


1. Газрын тосны ашиглалтын “Тосон-Уул-ХИХ”, “Тамсаг-ХХИ” талбайнуудад байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авсан “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг заасан хугацаанд Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (С.Амарсайхан)-т үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ




Ерөнхий сайдын 2022 оны 78 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	-Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан
Ажлын хэсгийн дэд ахлагч	-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон
Гишүүд:	-Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн; -Ерөнхий сайдын зөвлөх Д.Дашням; -Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат; -Засгийн газрын Жэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар; -Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал; -Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд; -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр.
Нарийн бичгийн дарга:	-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо.

---oOo---



Ерөнхий сайдын 2022 оны 78 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа дараахь удирдамжийг баримтална:

1. Газрын тосны ашиглалтын “Тосон-Уул-ХИХ” талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авсан “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх;
2. Газрын тосны ашиглалтын “Тамсаг-ХХИ” талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авсан “Петрочайна Дачин Тамсаг ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх;
3. Дээр дурдсан талбайнуудын талаар нэгдсэн дүгнэлт гаргаж, Засгийн газрын хуралдаанд оруулах санал боловсруулах;
4. Шаардлагатай бол мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх Дэд ажлын хэсгийг байгуулж ажиллуулах;
5. Ажлын хэсгийн дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байх.

---o0o---